

“ХОТ ТОХИЖИЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАНГИЙН МАЯГТ




2026 оны 01 дүгээр сарын 05

НЭГ. Товч танилцуулга
Газрын даргын 2025 оны А/79 дүгээр тушаалаар Ёс зүйн хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, Ёс зүйн хорооны даргаар Захиргаа хүний нөөцийн хэлтсийн дарга Б.Баасанбат, Гишүүнээр Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөд Ерөнхий нягтлан бодогч Б.Даваасүрэн, Дотоод хяналтын албаны дарга Г.Адъяасүрэн, Хөрөнгө оруулалт худалдан авах ажиллагааны албаны дарга Б.Их-Амгалан, Тохижилт үйлчилгээний албаны дарга Б.Нарантуяа, Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн Б.Баярмаа, Нарийн бичгээр Дотоод ажил, хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Байгаль нарын бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.
ХОЁР.Төрийн албан хаагчийн ёсзүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт
“Төрийн албан хаагчийн ёсзүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр 2024-2030 он” хэрэгжилтийг хангах төлөвлөгөө батлуулан, байгууллага төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлж, ёс зүйтэй, шударга ажиллах талаар ойлголт, хандлага, соёлын өөрчлөлт бий болгоход чиглэсэн ажлын байран дахь сургалтыг газрын Үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтарч “Манлайлал ба байгууллагын стрессийн менежмент” сургалтыг Авто бааз, Төвлөрсөн хогийн цэгүүдийн менежментийн алба, Тохижилт үйлчилгээний албаны ажлын байруудад зохион байгуулж, 120 ажилтан албан хаагчийг хамрууллаа. Захирагчийн ажлын албанаас харьяа газруудын Ёсзүйн хорооны дарга, нарийн бичиг нарт зориулсан “Төрийн албан хаагчийн ёсзүйн тухай хууль”-ийн 3 цагийн сургалтад 10 дугаар сарын 29-нд зохион байгуулж, тус сургалтад Захиргаа хүний нөөцийн хэлтсийн дарга Б.Баасанбат, Дотоод ажил хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Байгаль нар хамрагдсан. Хоёрдогч түүхий эд цуглуулагч иргэдэд зориулсан сургалтыг 2 удаа зохион байгууллаа. Үүнд: Монголын үг урлаачдын нийгэмлэгийн хүмүүлэгийн лектор Илтгэгч Б.Бандицэрэн /Чило/ илтгэл тавьж, түүхий эд цуглуулагч /ченж/ нартай хамтран, хог түүгч иргэдэд мэдээлэл хүргэх сургалтыг зохион байгуулж, сургалтад 183 хүн оролцлоо. “Гарц-Шийдэл” арга хэмжээний ерөнхий зохион байгуулагчаар СХД-ийн Засаг даргын Тамгын газартай хамтран Сонгинохайрхан дүүргийн 26, 41 дүгээр хорооны нутаг дэвсгэрт амьдарч байгаа айл өрхийн гишүүд, хүүхдүүдийн дэлгэрэнгүй судалгааг гаргаж, 36-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгийн ойр орчмын хөдөлмөрийн насны иргэдийг ажилд зуучлах, мэргэжлийн сургалтад хамруулах, бичил зээл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамруулах, орлого нэмэгдүүлэх боломж олгох олон асуудлаар хэлэлцэж, арга хэмжээ амжилттай зохион байгуулагдлаа.
2.2.Томилсон эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал
Авлигатай тэмцэх газраас Авлигын эсрэг олон улсын өдрийг угтан “Нийслэлийн төсөв асуудал, шийдэл: Иргэдийн хяналт” сэдэвт хэлэлцүүлгийг 12 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулж, дээрх хэлэлцүүлэгт газрын дарга Г.Ууганбаяр оролцов. 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн НИТХ-ын Засаглал, эрх зүйн хорооны хэлэлцүүлэг, арга хэмжээнд Захиргаа хүний нөөцийн хэлтсийн дарга Б.Баасанбат, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч Б.Даваасүрэн нар оролцсон.
2.3.Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа
Газрын даргын А/79 дүгээр тушаалаар Ёс зүйн хорооны чиг үүргийг баталж: - Төрийн албаны хууль, Төрийн албаны хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж шийдвэрийг удирдлага болгон хувь хүн, ажилтан албан хаагчдын нууцыг хадгалж, шударга байдлыг ханган, нотлох баримтанд үндэслэн улс төрөөс хараат бусаар зохион байгуулах;

- Газрын ажилтан, албан хаагчдад ёс зүйн мэдээлэл сургалт хийж, соён гэгээрүүлэх ажил зохион байгуулах;
- Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулах
- Ёс зүйн дэд хорооны ажлын тайлан мэдээг хууль тогтоомжийн дагуу Газрын даргад танилцуулж тайлагнах зэрэг ажлуудыг хариуцан гүйцэтгэлээ.

Гарсан үр дүн	Бэрхшээл
Нийт ажилтан албан хаагчдын дунд байгууллагын болон хувь хүний харилцаа хандлага, ажилдаа чин сэтгэлээсээ хандах хандлагууд өөрчлөгдсөн зэрэг эерэг үзүүлэлттэй байлаа.	
Санал	
Байгууллагын нийт ажилтан албан хаагчдад Удирдлагын академиас сургалт авах	

Сургалтын фото зураг



БАТАЛГААЖУУЛАЛТ:
ТОМИЛОХ ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН
ДАРГА Г.УУГАНБАЯР

ЁСЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА
ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.БААСАНБАТ

ЁСЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
ДОТООД АЖИЛ, ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Н.БАЙГАЛЬ